

“ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ БАТЛАХ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ
ЯВУУЛСАН ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ

2020 оны 08 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Г.Амартувшин, Х.Булгантуяа, Б.Жавхлан, Ч.Ундрам нараас 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн. Тус Байнгын хороо тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг 2020 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Коронавируст халдвартын цар тахлын үргэлжлэх хугацаа, үзүүлэх хүндрэлийг бүрэн тооцох боломжгүй, үүсээд байгаа сөрөг нөлөөллийг нийгэм, эдийн засагт хохирол, эрсдэл багатайгаар даван туулахад зээлийн хүүд нөлөөлж байгаа суурь шалтгааныг судалж, зээлийн хүүг бууруулахад баримтлах бодлогын чиглэлийг тодорхойлох шаардлагатай тулгараад байна. Энэхүү стратегийн зорилтот түвшинг хангахын тулд инфляцыг тогтвортой, нам төвшинд байлгах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, улсын гадаад өрийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийг төрөлжүүлэх, дотоод хуримтлалыг нэмэгдүүлэх, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшуулах зэрэг нарийвчилсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх юм. Тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор улсын төсөвт шууд нөлөө үзүүлэхгүй гэж хууль санаачлагч үзсэн байна.

Байнгын хорооны хэлэлцүүлгийн явцад Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр техникийн алдааг засах зорилгоор тогтоолын төслийн 2 дахь заалтын “жилийн” гэснийг “сарын” гэж өөрчлөх; гишүүн С.Чинзориг иргэдийн орлого зарцуулалтад сөрөг нөлөө үзүүлж байгаа хэрэглээний зээлийн дарамтыг бууруулах зорилгоор банкны зээлийн бүтээгдэхүүнийг боловсронгуй болгож, иргэдийн шууд орлогоор барьцаалсан бүтээгдэхүүнд өөрчлөлт оруулах; гишүүн Т.Доржханд дэлхийн олон оронд ашиглаж байгаа шийдлийг хэрэгжүүлж мөнгө хүүлэлтийг хязгаарлах зорилгоор зээлийн хүүгийн хязгаарыг тогтоох тухай заалт шинээр нэмэх санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр төслийн хавсралтын 1.6.1 дэх дэд заалтад хэрэгжүүлэх хугацааг “2020-2024” гэж нэмэх; мөн хавсралтын 2.1 дэх заалтын “2020-2021” гэснийг хасах; гишүүн Ж.Ганбаатар 2.1.3 дахь дэд заалт буюу банкны зээлийн хоёрдогч захыг активын удирдлагын мэргэшсэн институцийн хүрээнд зохицуулах нь банкнуудын хариуцлагыг супруулах бөгөөд салбарт авчрах сөрөг нөлөө их байгааг дурдаж, энэ заалтыг хасах; гишүүн Х.Ганхуяг тогтоолын хэрэгжүүлэх хугацааг 2021 оны эцэс байхаар өөрчлөх; гишүүн Т.Доржханд банкны тусгай зөвшөөрлийг ангилдаг болох, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд Засгийн газрын бонд гаргаж, хөрөнгө оруулагчдад шинэ бүтээгдэхүүн санал болгож өрсөлдөөнийг дэмжих хөшүүрэг бий болгох, хадгаламжийн хэмжээнээс хамаарч

хүүгийн орлогод шаталсан татвар тогтоох гэсэн санал тус тус гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

“Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Байнгын хороо дэмжсэн, дэмжээгүйгээр нь бүлэглэн Түүхэнд тараасан.


Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, зарчмын зөрүүтэй саналуудаар санал хурааж өгөхийг Түүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ж.ГАНБААТАР



2020.08.25

**“ЗЭЭЛИЙН ХҮҮГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ БАТЛАХ ТУХАЙ”
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

НЭГ. Байнгын хороо дэмжсэн санал

1.Тогтоолын төслийн 2 дахь заалтын “жилийн” гэснийг “сарын” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр

2.Тогтоолын төслийн хавсралтад доор дурдсан агуулга бүхий 1.5.6 дахь заалт шинээр нэмэх:

“1.5.6.Банкны зээлийн бүтээгдэхүүнийг боловсронгуй болгож иргэдийн шууд орлогоор барьцаалсан бүтээгдэхүүнд өөрчлөлт оруулах”.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг

3.Тогтоолын төслийн хавсралтад доор дурдсан агуулга бүхий 2.4.4 дэх заалт шинээр нэмэх:

“2.4.4.Мөнгө хүүлэлтийг хязгаарлах зорилгоор зээлийн хүүгийн хязгаарыг тогтоох (Банк, банк бус буюу тусгай зөвшөөрлөөр зээл олгодог байгууллагуудын хүү)”.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд

ХОЁР. Байнгын хороо дэмжээгүй санал

1.Тогтоолын төслийн хавсралтын 2.1.3 дахь заалтыг хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар

2.Тогтоолын төслийн хавсралтын 1.6.1 дэх заалтад хэрэгжүүлэх хугацааг “2020-2024” гэж нэмэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр

3.Тогтоолын төслийн хавсралтын 2.1 дэх заалтын “, 2020-2021” гэснийг хасах;

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр

4.Тогтоолын төслийн 2 дахь заалтын “2023” гэснийг “2021” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг

5.Тогтоолын төслийн хавсралтад доор дурдсан агуулга бүхий 1.8.2 дахь заалт шинээр нэмэх:

“1.8.2.Банкны тусгай зөвшөөрлийг ангилах:

- 1/хөрөнгө оруулалтын (байгууллагын);
- 2/иргэдийн.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд

6.Тогтоолын төслийн хавсралтад доор дурдсан агуулга бүхий 4.1.2 дахь заалт шинээр нэмэх:

“4.1.2.Засгийн газрын бондыг тогтмол гаргаж, дотоодын үнэт цаасны суурь хүүг тогтоох”.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд

7.Тогтоолын төслийн хавсралтад доор дурдсан агуулга бүхий 1.6.6 дахь заалт шинээр нэмэх:

“1.6.6.Хадгаламжийн хэмжээнээс хамаарч хүүгийн орлогод шаталсан татвар тогтоох”.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО